



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

ПАЛЕОНТОЛОГИ, ГЕОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
Х.ЦОГТБААТАР ТАНАА

2017.02.20 № 3/227
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Палеонтологи, геологийн хүрээлэн нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ПАЛЕОНТОЛОГИ, ГЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

ТАБ-ын Тэргүүлэх аудитор: С.Энхзаяа
Утас: 261663

Цахим хаяг: enkhzaya@audit.gov.mn

Аудитын менежер: Н.Золзаяа
Утас: 260512

Цахим хаяг: zolzaya@audit.gov.mn

Аудитор: Ц.Сугармаа
Утас: 99151254

Цахим хаяг: sugarmaa23@gmail.com

Компанийн хаяг: “И Эс Эс Эс Аудит” ХХК
Байршил: СБД, 1-р хороо Жамьяан гүний
гудамж-5, Ар Монгол Травэлийн байр
Цахим хаяг: esss.audit@gmail.com

2017 оны 2 дугаар сар

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

- 1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл**
- 2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин**
- 3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа**
- 4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн**
- 5. Дотоод хяналт**
- 6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар**
- 7. Шилэн дансны мэдээлэл**
- 8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар**
- 9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар**
- 10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**
- 11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**
- 12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал**
- 13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд**
- 14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**
- 15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**
- 16. Зөвлөмж**
- 17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт**

НЭГ. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Палеонтологи, геологийн хүрээлэнгийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-2017/337/СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Хүрээлэнгийн захирал санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн төсвийн 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөж, тус компанийн ахлах аудитор Д.Лхагвасүрэн хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/, /ТАБ-СТА-А-10/

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 20-нд тус компанид ирүүлсэн тул хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

Тус компани аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 20-ноос 2017 оны 2 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 20-ны дотор УАГ-ын холбогдох албан тушаалтнуудаар хянуулсны дараагаар дүгнэлтийг албан ёсоор болгож, Палеонтологи, геологийн хүрээлэнгийн удирдлагад гардуулна.

ХОЁР. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн удирдлага нь Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн албаны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

ГУРАВ. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн гол зорилго нь Монгол орны палеонтологи, геологийн судалгааг олон улсын түвшинд хүргэх, шинэ мэдлэг хуримтлуулах, ололтыг түгээхэд оршиж байна.

Үндсэн чиг үүрэг нь: Үлэг гүрвэлийн судалгаа, удам төрлийн харилцаа холбоог нарийвчлан гаргах, гол төрлүүдийн харьцуулах үндэслэл, биологи, зан үйлийн мэдээллийг тодотгох, зарим үлэг гүрвэлийн бүлгийн филогенезийн судалгааг гүнзгийрүүлэн хийж, шинэ төрөл, шинэ зүйл тогтоох, палеобиогеографийн болон палеоэкологийн талаарх ойлголтод шинэ таамаглалыг дэвшүүлэх боломжийг нээх явдал юм.

Монгол Улсын ЗГ-ын 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор Палеонтологийн төв нь Геологийн төвтэй нийлж, Палеонтологи, геологийн хүрээлэн болж, шинэ бүтэц зохион байгуулалтаар ажиллах болжээ.

Хүрээлэн нь Шинжлэх Ухааны Академийн харьяалалд багтдаг бөгөөд төсвийн санхүүгийн тайланг гаргаж, Шинжлэх ухаан технологийн сангийн тайлангийн нэгтгэлд нэгтгэгддэг.

Палеонтологи, геологийн хүрээлэнтэй холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хөдөлмөрийн тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Шинжлэх ухаан, Технологийн тухай, ШУ-ны эрх зүйн байдлын тухай, Инновацийн тухай, Авилгатай тэмцэх тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиуд болон ШУА-ын дүрмийг мөрдөж ажиллаж байна.

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

ДӨРӨВ. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Палеонтологи, геологийн хүрээлэнгийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төслийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжуулав. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилыг данс бүрээр түүвэрлэн гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Палеонтологи, геологийн хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн төсөвт байгууллагын нягтлан бодох системийн Санхүүгийн тооцоолох ХХК-иас гаргасан ACOLOUS програмыг ашиглаж, санхүүгийн тайланг гаргаж байна.

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Материаллаг түвшинг тооцохдоо төлөвлөлтийн шатанд нийт хөрөнгийн дүнгээс 1 хувиар буюу 4.63 сая төгрөгөөр урьдчилан тооцсон бөгөөд гүйцэтгэлийн шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзэв.

ТАВ. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дотоод аудиторын орон тоо байхгүй бөгөөд БСШУСЯ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас шилэн дансны хэрэгжилтийг тайлант жилд 1 удаа шалгасан байна. Байгууллагын удирдлага болон ерөнхий нягтлан бодогч өдөр тутмын ажлуудад хяналт тавьж ажиллаж байна.

ЗУРГАА. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

БСШУС-ын сайдын 2016 оны батлагдсан төсвөөс ШУТС-аар дамжуулан сар, улирлын хуваарийн дагуу санхүүжилтийг Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжилтийн эрх нээж, санхүүжилтийг олгож байна

Тус хүрээлэн нь 2016 онд урсгал зардалд нийт 889.7 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 885.3 сая төгрөгийг авч, зтөсвийг 4.4 сая төгрөгөөр хэмнэжээ.

2016 онд санхүүжилтийн орлого 889.7 сая төгрөг, ШУТС-гаас 19.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 3.8 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 709.4 сая төгрөг нийт 1621.9 сая төгрөгийг орлогоор бүртгэсэн байна.

ДОЛОО. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2016 оны нийт зээлийн хөрөнгөөр баталсан төсөв болон гүйцэтгэлийн талаарх мэдээлэл, ажлын гүйцэтгэл, бусад холбогдох мэдээллийн талаар вэбсайт хуудсанд байршуулсан бөгөөд яамны ХШҮДАГ-аас шилэн дансны мэдээлэлд үнэлэлт дүгнэлт өгсөн байна.

Тайлант жилд шилэн дансны мэдээлэлд сар бүрийн төсвийн хуваарийн дагуу сарын зарцуулалтын мэдээ, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйлгээнүүд, өмнөх оны санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангуудыг оруулж бүртгэсэн байна.

НАЙМ. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын данс бүрээр эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд орлого, зарлагын дансны зүйл ангиар задалвал нийт 11 нарийвчилсан горим, сорил хийж дүгнэв.

Аудитаар гаргасан доорх эрсдлүүд нь Монгол Улсын Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлээгүйгээс шалтгаалж, хяналтыг сулруулж, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүргэж болзошгүй юм.

ЕС. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, санхүүжилтийн орлого, нэмэлт орлого, өөрийн орлого болон зардлаас бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, урсгал зардал дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын санхүүжилтийн, нэмэлт, нийгмийн даатгалын болон үйл ажиллагааны орлогын дүнгээс 100 хувь, зардлын зүйл ангиллын дагуу бичиг хэргийн, урсгал зардал, гадаад дотоод томилолтын зардлын 60-70 хувийг тус тус түүвэрчилсэн сорил хэрэгжүүлсэн болно.

АРАВ. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад дараах материаллаг бус алдаа илэрлээ. /ТАБ-СТА-В-4/ Үүнд:

1. БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтаар тайлант жилд тус хүрээлэнгийн 8 дугаар байрны гадна талын пасадыг 17.5 сая төгрөгөөр хийсэн боловч албан ёсоор хийсэн ажлын гүйцэтгэл гаргаж, баталгаажуулсан шийдвэрийг өгөөгүй тул хөрөнгийг нэмэгдүүлж орлогоор бүртгээгүй нь УСНББОУС17-д заасны дагуу сайжруулсан зардлыг нэмэгдүүлж хөрөнгөөр бүртгэх нь зүйтэй.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн сайжруулалт дууссан тул холбогдох баримт материалыг үндэслэн хөрөнгийг капиталжуулж бүртгэх нь зүйтэй.

2. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 11 дүгээр тогтоолоор Үлэг гүрвэлийн төв музей байгуулахаар шийдвэрлэсэн байна. Энэхүү тогтоолын хүрээнд шинээр байгуулагдаж буй Үлэг гүрвэлийн төв музейд Шинжлэх Ухаан Академийн Палеонтологийн төвийн дэргэдэх музейг нэгтгэж, тус музейн үзмэрүүдийг үзмэр харагчийн орон тоо, цалингийн сангийн хамтаар шилжүүлэхээр шийдвэрлэжээ. Тогтоолын хүрээнд ТӨХ-ны тогтоол гарч, ажлын хэсэг байгуулж, хүлээлцэхээр болсон боловч өнөөдрийн байдлаар хөрөнгийг шилжүүлээгүй, тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Засгийн газрын тогтоолыг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй.

3. Үзэсгэлэнгийн орлого төвлөрүүлэх зориулалт бүхий дансыг 2014 онд Сангийн яамны Төрийн сангийн дарга Ч.Тавинжилийн 2014 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн 9-2/3520 дугаар албан бичгээр “Төрийн сангийн нэгдсэн дансанд орлого төвлөрүүлэх зориулалттай үзэсгэлэнгийн орлогын” 900015901 дугаар дансыг нээсэн бөгөөд үзэсгэлэнгийн орлогын үлдэгдэл 598.0 сая төгрөгийг дээрх дансанд төвлөрүүлээгүй, нэмэлт дансны орлого, зарлагын гүйлгээтэй хольж байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Үзэсгэлэнгийн орлогын үлдэгдлийг 900015901 дансанд тусд нь байршуулах нь зүйтэй.

АРВАН НЭГ. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг алдаа тогтоогдоогүй болно.

АРВАН ХОЁР. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

“Төрийн сангийн нэгдсэн дансанд орлого төвлөрүүлэх зориулалттай үзэсгэлэнгийн орлогын” 900015901 дугаар дансыг нээсэн бөгөөд үзэсгэлэнгийн орлогын үлдэгдэл 598.0 сая төгрөгийг түүнд байршуулах нь зүйтэй.

АРВАН ГУРАВ. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үзэж дүгнэлт гаргах болно.

АРВАН ДӨРӨВ. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Аудитаар илэрсэн зүйл дээр аудитаар гарсан материаллаг бус алдаа зөрчлийн талаар тодорхой бичиж, зөвлөмж өгөв.

АРВАН ТАВ. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнө нь тусгайлан санхүүгийн аудит хийгдэж байгаагүй байна.

АРВАН ЗУРГАА. Зөвлөмж:

Менежментийн захидалд материаллаг бус алдаа, зөрчлийн талаар бичиж, зөвлөмж өгсөн болно.

АРВАН ДОЛОО. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Зөрчилгүй санал дүгнэлт

Палеонтологи, геологийн хүрээлэнгийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон тодруулга, тэмдэглэлийг тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан болон бусад холбогдох хавсралт хуудсуудыг тус тус хавсаргав.



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ПАЛЕОНТОЛОГИ, ГЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Үндсэн хөрөнгө.....3

Асуудал 2

Хууль эрх зүй.....4

Асуудал 3

Орлого.....5

2017 оны 2 дугаар сар

Менежментийн захидал

Бид аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Палеонтологи, Геологийн хүрээлэнгийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Тус компани энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой өгч байгаа бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Палеонтологи, Геологийн хүрээлэнгийн удирдлага болон санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтаар тайлант жилд тус хүрээлэнгийн 8 дугаар байрны гадна талын пасадыг 17.5 сая төгрөгөөр хийсэн боловч албан ёсоор хийсэн ажлын гүйцэтгэл гаргаж, баталгаажуулсан шийдвэрийг өгөөгүй тул хөрөнгийг нэмэгдүүлж орлогоор бүртгээгүй нь УСНББОУС17-д заасны дагуу сайжруулсан зардлыг нэмэгдүүлж хөрөнгөөр бүртгэх нь зүйтэй.

ҮАГ-ын зөвлөмж

Хөрөнгийн сайжруулалт дууссан тул холбогдох баримт материалыг үндэслэн хөрөнгийг капиталжуулж бүртгэх

Эрсдэлүүд

Хөрөнгийг нэмэгдүүлсэн дүнгээр илэрхийлээгүй байх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг Асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

ҮАГ-ын ажиглалт

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 11 дүгээр тогтоолоор Үлэг гүрвэлийн төв музей байгуулахаар шийдвэрлэсэн байна. Энэхүү тогтоолын хүрээнд шинээр байгуулагдаж буй Үлэг гүрвэлийн төв музейд Шинжлэх Ухаан Академийн Палеонтологийн төвийн дэргэдэх музейг нэгтгэж, тус музейн үзмэрүүдийг үзмэр харагчийн орон тоо, цалингийн сангийн хамтаар шилжүүлэхээр шийдвэрлэжээ. Тогтоолын хүрээнд ТӨХ-ны тогтоол гарч, ажлын хэсэг байгуулж, хүлээлцэхээр болсон боловч өнөөдрийн байдлаар хөрөнгийг шилжүүлээгүй, тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэлүүд

Хууль эрх зүйн актыг мөрдөөгүй байх

ҮАГ-ын зөвлөмж

Монгол Улсын Засгийн газрын тогтоолыг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг Асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

Асуудал 3: Орлогын талаар	Тэргүүлэх ач холбогдол №3
----------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Үзэсгэлэнгийн орлого төвлөрүүлэх зориулалт бүхий дансыг 2014 онд Сангийн яамны Төрийн сангийн дарга Ч.Тавинжилийн 2014 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн 9-2/3520 дугаар албан бичгээр “Төрийн сангийн нэгдсэн дансанд орлого төвлөрүүлэх зориулалттай үзэсгэлэнгийн орлогын” 900015901 дугаар дансыг нээсэн бөгөөд үзэсгэлэнгийн орлогын үлдэгдэл 598.0 сая төгрөгийг дээрх дансанд төвлөрүүлээгүй, нэмэлт дансны орлого, зарлагын гүйлгээтэй хольж байршуулсан байна.

Эрсдэлүүд

Орлого буруу ангилагдах

ҮАГ-ын зөвлөмж

Үзэсгэлэнгийн орлогын үлдэгдлийг 900015901 дансанд тусд нь байршуулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг Асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		728,878,674.39	765,810,175.85
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	3	0.00	8,000.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		0.00	8,000.00
31110	Төгрөг		0.00	0.00
31130	Нэмэлт санхүүжилт		-	8,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		0.00	0.00
3121	Төгрөг		0.00	0.00
31211	Төрийн сангийн харилцах		0.00	0.00
33	АВЛАГА	4	553,056,686.34	599,257,739.39
335	Бусад авлага		553,056,686.34	599,257,739.39
3351	Байгууллагаас авах авлага		553,056,686.34	599,257,739.39
34	УРЬДЧИЛГАА	5	15,449,300.00	14,401,745.00
34600	Урьдчилж гарсан зардал		61,000.00	483,332.00
3471	Урьдчилгаа тооцоо		15,388,300.00	13,918,413.00
34714	Томилолтын урьдчилгаа		15,388,300.00	13,918,413.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6	160,372,688.05	152,142,691.46
351	Түүхий эд материал		11,609,921.00	10,268,488.18
35110	Тусгай зориулалттай материал		11,609,921.00	10,268,488.18
354	Хангамжийн материал		148,762,767.05	141,874,203.28
35410	Бичиг хэргийн материал		10,859,420.00	7,713,140.00
35420	Аж ахуйн материал		91,409,918.05	83,882,915.28
35430	Сэлбэг хэрэгсэл		-	450,000.00
35450	Барилгын засварын материал		2,967,200.00	2,000,500.00
35470	Бусад хангамжийн материал		43,526,229.00	47,827,648.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7	2,870,723,978.10	2,815,680,263.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		2,870,723,978.10	2,815,680,263.86
392	Биет хөрөнгө		2,869,151,894.77	2,814,639,847.13
39201	Барилга, байгууламж		1,232,151,373.00	1,232,151,373.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		(608,590,278.24)	(631,861,290.48)
39203	Авто тээврийн хэрэгсэл		104,351,780.00	104,351,780.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(85,473,297.62)	(94,157,762.00)
39205	Машин, тоног төхөөрөмж		927,678,644.00	945,089,644.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		(852,042,829.49)	(889,348,589.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		112,222,592.32	118,892,692.32
39208	Хуримтлагдсан элэгдэл		(71,110,577.91)	(79,696,818.71)
39213	Түүх соёлын дурсгалт зүйлс		2,100,901,905.00	2,100,901,905.00
39214	Бусад үндсэн хөрөнгө		112,026,190.00	112,026,190.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(108,197,743.34)	(108,943,413.38)
39217	Номын фонд		5,234,137.05	5,234,137.05
393	Биет бус хөрөнгө		1,572,083.33	1,040,416.73
39301	Програм хангамж		3,595,000.00	3,595,000.00
39302	Хасагдуулга		(2,022,916.67)	(2,554,583.27)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		3,599,602,652.49	3,581,490,439.71

413	ӨГЛӨГ	8	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН		3,599,602,652.49	3,581,490,439.71
51	Засгийн газрын хувь оролцоо		3,599,602,652.49	3,581,490,439.71
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан		1,333,002,809.00	1,333,002,809.00
51101	Өмч: -Төрийн өмч		1,333,002,809.00	1,333,002,809.00
512	Хуримтлагдсан үр дүн		627,507,222.57	609,395,009.79
51210	Өмнөх үеийн үр дүн		627,507,222.57	627,507,222.57
51220	Тайлант үеийн үр дүн		-	(18,112,212.78)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,639,092,620.92	1,639,092,620.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН		3,599,602,652.49	3,581,490,439.71

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1	1,891,293,199.17	1,073,970,728.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		862,095,886.32	8,870,680.00
120	Нийтлэг татварын бус орлого		862,095,886.32	8,870,680.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		862,095,886.32	8,870,680.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		8,000,000.00	3,810,550.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		854,095,886.32	5,060,130.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,029,197,312.85	1,065,100,048.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		799,283,310.85	889,747,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		799,283,310.85	889,747,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		229,914,002.00	175,352,748.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи		71,790,100.00	19,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		158,123,902.00	156,352,748.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	2	1,123,580,062.45	1,092,082,940.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,083,594,428.38	1,081,743,565.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,083,594,428.38	1,081,743,565.48
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		727,402,220.00	712,902,130.37
210101	Цалин		696,202,220.00	700,752,130.37
210105	Гэрээтийн цалин		31,200,000.00	12,150,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		76,170,231.95	78,151,891.09
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл		62,362,192.67	51,442,049.19
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл		2,761,607.85	5,341,968.39
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		3,452,009.83	6,677,460.49
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл		690,401.99	1,335,492.09
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж		6,904,019.61	13,354,920.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		31,274,639.15	32,609,696.83
210301	Гэрэл цахилгааны зардал		9,149,415.00	11,310,150.98
210302	Түлш, халаалтын зардал		19,589,116.17	19,500,896.85
210303	Цэвэр, бохир усны зардал		2,536,107.98	1,798,649.00
2104	Хангамж, бараа материалын зардал		5,128,813.72	4,800,257.51
210401	Бичиг хэргийн материал		28,500.00	-
210402	Тээвэр, шатахууны зардал		2,629,000.00	945,668.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр		1,893,313.72	2,862,279.51
210404	Ном, хэвлэлийн зардал		578,000.00	-
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх		-	900,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс		-	92,310.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		118,200.00	1,076,000.00
210604	Урсгал засвар		118,200.00	1,076,000.00
2107	Томилолт, зочны зардал		83,984,680.00	77,723,022.00
210701	Гадаад томилолтын зардал		5,036,800.00	2,954,660.00
210702	Дотоод томилолтын зардал		78,947,880.00	74,768,362.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж		17,385,562.50	42,621,297.85

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		17,360,636.80	40,333,899.85
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал		-	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр		-	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		-	187,000.00
210807	Газрын төлбөр		-	1,002,388.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		24,925.70	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		142,130,081.06	131,859,269.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		40,347,298.35	52,734,455.59
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		101,782,782.71	79,124,814.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		39,985,634.07	10,339,375.30
2132	Бусад урсгал шилжүүлэг		20,157,700.00	2,120,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		20,157,700.00	920,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		-	1,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		19,827,934.07	8,218,675.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		19,827,934.07	8,218,675.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)		767,713,136.72	(18,112,212.78)
7	НИИТ ҮР ДҮН (VII=III+VI)		767,713,136.72	(18,112,212.78)

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
	2015 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	00.00	00.00	00.00	00.00
	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	00.00	00.00	00.00	00.00
	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	00.00	00.00	00.00	00.00
	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	00.00	00.00	00.00	00.00
	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,333,002,809.00	1,639,092,620.92	627,507,222.57	3,599,602,652.49
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,333,002,809.00	1,639,092,620.92	627,507,222.57	3,599,602,652.49
	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	00.00	00.00	00.00	00.00
	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	00.00	00.00	00.00	00.00
	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	00.00	00.00	00.00	00.00
	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	00.00	00.00	-18,112,212.78	-18,112,212.78
	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,333,002,809.00	1,639,092,620.92	609,395,009.79	3,581,490,439.71

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1	1,597,334,674.39	1,628,910,692.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		633,952,712.39	3,818,365.95
120	Нийтлэг татварын бус орлого		633,952,712.39	3,818,365.95
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		633,952,712.39	3,818,365.95
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		8,000,000.00	3,818,365.95
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		625,952,712.39	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		963,381,962.00	1,625,092,326.39
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		733,107,960.00	889,747,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		733,107,960.00	889,747,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		230,274,002.00	728,401,618.39
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи		72,150,100.00	19,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		158,123,902.00	709,401,618.39
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		-	6,943,408.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		-	6,943,408.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	2	1,578,966,100.08	1,606,118,592.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,578,966,100.08	1,606,118,592.34
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		985,931,595.62	997,730,346.65
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		667,509,741.66	719,845,538.37
210101	Үндсэн цалин		636,309,741.66	707,695,538.37
210105	Гэрээт ажлын хөлс		31,200,000.00	12,150,000.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл		70,217,031.95	78,151,891.09
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл		52,386,186.99	51,442,049.19
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл		3,697,602.96	5,341,968.39
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		4,622,003.82	6,677,460.49
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл		864,658.07	1,335,492.09
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж		8,646,580.11	13,354,920.93
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал		30,910,484.19	33,818,565.83
210301	Гэрэл цахилгааны зардал		9,149,415.00	12,519,019.98
210302	Түлш, халаалтын зардал		19,224,961.21	19,500,896.85
210303	Цэвэр, бохир усны зардал		2,536,107.98	1,798,649.00
2104	Хангамж, бараа материалын зардал		19,258,029.72	6,073,424.51
210401	Бичиг хэрэг		1,147,050.00	818,535.00
210402	Тээвэр, шатахуун		2,690,000.00	1,368,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,893,313.72	2,862,279.51
210404	Ном, хэвлэл		10,030,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		-	900,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,497,666.00	124,610.00
2105	Нормативт зардал		922,250.00	1,967,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		922,250.00	1,967,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		29,104,180.00	7,240,100.00
210601	Багаж техник хэрэгсэл		2,000,000.00	-
210602	Тавилга		6,583,560.00	-
210604	Урсгал засвар		20,520,620.00	7,240,100.00
2107	Томилолт, зочны зардал		98,806,680.00	74,319,435.00
210701	Гадаад албан томилолт		5,036,800.00	2,954,660.00
210701	Дотоод албан томилолт		93,769,880.00	71,364,775.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		40,565,263.50	60,922,076.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж		40,540,337.80	58,634,678.85
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		-	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		-	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		-	187,000.00
210807	Газрын төлбөр		-	1,002,388.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		24,925.70	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		28,637,934.60	15,391,615.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		28,637,934.60	15,391,615.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		593,034,504.46	608,388,245.69
2132	Бусад урсгал шилжүүлэг		20,157,700.00	2,120,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		20,157,700.00	920,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		-	1,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		572,876,804.46	606,267,545.69
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		572,876,804.46	606,267,545.69
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		18,368,574.31	22,792,100.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		18,393,500.00	22,784,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		18,393,500.00	22,784,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр		18,393,500.00	22,784,100.00
225102	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал /ТӨҮГ/		18,393,500.00	22,784,100.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		(18,393,500.00)	(22,784,100.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		(24,925.69)	8,000.00
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	0.00
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	8,000.00

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	897,747,300.00	889,098,115.65	8,649,184.35	96.90
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	897,747,300.00	889,098,115.65	8,649,184.35	96.90
Бараа, үйлчилгээний зардал	897,747,300.00	889,098,115.65	8,649,184.35	96.90
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	678,577,200.00	678,336,163.07	241,036.93	99.96
Үндсэн цалин	678,577,200.00	678,336,163.07	241,036.93	99.96
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,643,500.00	73,452,065.21	1,191,434.79	98.40
Тэтгэврийн даатгал	74,643,500.00	46,742,223.31	27,901,276.69	62.62
Тэтгэмжийн даатгал	-	5,341,968.39	(5,341,968.39)	-
ҮОМШӨ ний даатгал	-	6,677,460.49	(6,677,460.49)	-
Ажилгүйдлийн даатгал	-	1,335,492.09	(1,335,492.09)	-
Эрүүл мэндийн даатгал	-	13,354,920.93	(13,354,920.93)	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,400,000.00	32,994,565.83	5,405,434.17	85.92
Гэрэл цахилгаан	16,500,000.00	11,719,019.98	4,780,980.02	71.02
Түлш, халаалт	18,500,000.00	19,500,896.85	(1,000,896.85)	105.41
Цэвэр, бохир ус	3,400,000.00	1,774,649.00	1,625,351.00	52.20
Хангамж, бараа материалын зардал	5,004,800.00	4,739,389.51	265,410.49	94.70
Бичиг хэрэг	435,400.00	434,500.00	900.00	99.79
Тээвэр (шатахуун)	1,368,000.00	1,368,000.00	-	100.00
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,688,200.00	2,662,279.51	25,920.49	99.04
Ном, хэвлэл	225,000.00	-	225,000.00	-
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.00	150,000.00	-	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	138,200.00	124,610.00	13,590.00	90.17
Нормативт зардал	1,967,700.00	1,967,700.00	-	100.00
Нормын хувцас зөөлөн эдлэл	1,967,700.00	1,967,700.00	-	100.00
Эд хогшил худалдан авах	378,600.00	201,000.00	177,600.00	53.09
Урсгал засвар	378,600.00	201,000.00	177,600.00	53.09
Томилолт, зочны зардал	17,709,000.00	17,709,000.00	-	100.00
Дотоод албан томилолт	17,709,000.00	17,709,000.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	81,066,500.00	79,698,232.03	1,368,267.97	79.01
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,814,000.00	77,535,834.03	1,278,165.97	78.63
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
Даатгалын үйлчилгээ	98,100.00	98,010.00	90.00	99.91
Тээврийн хэрэгслийн татвар	187,000.00	187,000.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	90,000.00	-	90,000.00	-
Газрын төлбөр	877,400.00	877,388.00	12.00	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	897,747,300.00	889,098,115.65	8,649,184.35	99.04
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	889,747,300.00	885,279,749.70	4,467,550.30	99.50
Улсын төсвөөс санхүүжих	889,747,300.00	885,279,749.70	4,467,550.30	99.50
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,000,000.00	3,818,365.95	4,181,634.05	47.73

Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	3,818,365.95	4,181,634.05	47.73
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00		
АЖИЛЛАГСДЫН ТОО	82.00	82.00		
Удирдах ажилтан	1.00	1.00		
Гүйцэтгэх ажилтан	59.00	59.00		
Үйлчлэх ажилтан	22.00	22.00		

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	724,642,493.39	
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	724,642,493.39	
Бараа, үйлчилгээний зардал	-	124,472,923.00	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	34,565,967.30	
Үндсэн цалин	-	22,415,967.30	
Гэрээт ажлын хөлс	-	12,150,000.00	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	4,699,825.88	
Тэтгэврийн даатгал	-	4,699,825.88	
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	824,000.00	
Гэрэл цахилгаан	-	800,000.00	
Цэвэр, бохир ус	-	24,000.00	
Хангамж, бараа материалын зардал	-	1,334,035.00	
Бичиг хэрэг	-	384,035.00	
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	-	200,000.00	
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	750,000.00	
Эд хогшил худалдан авах	-	7,039,100.00	
Урсгал засвар	-	7,039,100.00	
Томилолт, зочны зардал	-	56,610,435.00	
Гадаад албан томилолт	-	2,954,660.00	
Дотоод албан томилолт	-	53,655,775.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	4,007,944.82	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	3,882,944.82	
Газрын төлбөр	-	125,000.00	
Бараа үйлчилгээний бусад зардал	-	15,391,615.00	
Бараа үйлчилгээний бусад зардал	-	15,391,615.00	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	600,169,570.39	
Бусад урсгал шилжүүлэг	-	2,120,700.00	
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	920,700.00	
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	1,200,000.00	
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	598,048,870.39	
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	598,048,870.39	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	724,650,493.39	
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	724,650,493.39	
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	17,436,595.00	
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	707,213,898.39	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	8,000.00	